



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 28 өдөр

Дугаар АББ

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн наймдугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтын 3.6 дахь заалтын "Сүү махан бүтээгдэхүүний антибиотикийн үлдэгдэл илрүүлэх багаж" 4,2 сая, 3.7 дахь заалтын "Мал эмнэлгийн лабораторийн эм урвалж оношлуурын тест" 11,0 сая, төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д шилжүүлсүгэй.

2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 2 дугаар сарын 20-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 3 дугаар сарын 25-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 8 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/-д хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ